



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 6/15

Өмнөдэлгэр сум

**Д.Шинэтуяад ажил хавсруулан
гүйцэтгүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн номын санч Дагвасүрэнгийн Шинэтуяад 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Соёлын төвийн дарга томилогдох хүртэлх хугацаанд Соёлын төвийн даргын үүрэгт ажлыг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2.Д.Шинэтуяад Соёлын тухай хуулийн 25.2-т заасан чиг үүрэг, цалин хөлсний хэмжээ, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулахыг нийгмийн бодлогын мэргэжилтэн (Т.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

3.Холбогдох хууль, журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн, идэвх санаачилгатай ажиллахыг Д.Шинэтуяад үүрэг болгосугай.

4.Д.Шинэтуяад ажил хавсарсны нэмэгдэл үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Б.ЭРДЭНЭБААТАР